Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,858,052.4 мянган төгрөг болж 525,495.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Өнөр бүл хүүхдийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 56,154.4 мянган төгрөгөөр буюу 102.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 451,298.6 мянган төгрөгөөр өсчээ. Энэ нь багш, ажилчдын цалин, урсгал зардал болон хүнсний материалын үнэ өссөнтэй холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж баталсан нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 28,866.4 мянган төгрөгөөр буюу 101.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа, ажил үйлчилгээний зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 2,446,311.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Өмнөх оны төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс тайлант онд 423,080.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,446,311.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тус төвийн багш ажилчдын цалин боловсролын ажилтны шатлалд шилжсэнтэй холбоотой ажилчдын цалин хөлсийг нэмж шинэчилсэн ба цахилгаан, ус дулааны төлбөр, хүнсний материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотой үнийн өөрчлөлтийг төсөвт тусгасныг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зөвшөөрч нэмж баталжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 30 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,446,311.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,446,311.5 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 2,445,722.0 мянган төгрөгийг зарцуулж 589.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,445,722.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 487.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 17.4 мянга, хангамж, бараа материалын зардлыг 8.4 мянга, томилолт, зочны зардал 18.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 4.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 18.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 4 хөтөлбөрийн 5 арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Петростар ХХК-аас үнэ төлбөргүй хүлээн авсан шатахууны 698.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 12,040.0 мянга төгрөгийг “Өнөр бүл хүүхдийн төв”-ийг төгсөж гарсан хүүхдүүдийн уулзалт болон ар гэрийн нөхцөл байдлыг үнэлэх ажлын зориулалтаар олгогдсон байна.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 7,040.0 мянга, тээвэр, шатахууны зардалд 698.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,000.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 476 мэдээллээс 398 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийн хугацаа болоогүй, 40 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 243,326.4 мянган төгрөгийн 37 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.

3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8,734.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн, өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт							
Албан шаардлага	1	8,734.2	1	8,734.2	-	-	100.0
Зөвлөмж	3	-	2	-	1	-	66.7
Нийт дүн	4	8,734.2	3	8,734.2	2		

3.9 Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 599,021.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 308,968.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,888.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 259,538.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 27,626.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тогтмол зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний 282,206.4 мянган төгрөгийн төлбөр төлөхдөө өглөг, авлагын тооцоо үүсгэлгүй зардлаар шууд бүртгэснийг залруулав.
2. Хангамжийн материалыг тавьж олгохдоо ашиглалтын норм нормативыг мөрдөөгүй, зардлаар шууд бүртгэсэн 26,761.9 мянган төгрөгийн зардлыг залруулж бараа материалын үлдэгдлээр залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Залруулагдаагүй зөрчлөөс 2,888.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 259,538.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шатахууны зардлыг автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормоос 2,888.1 мянган төгрөгөөр илүү зарцуулсан ба жолоочийн замын хуудас засвартай, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар 1 хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 3 бүлэг "Зардлыг хүлээн зөвшөөрөх ба үнэлэх" хэсгийн 3.2 дахь заалт "... гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Оны эцэст 16,212.5 мянган төгрөгийн шатахуун авч нөөцөлсөн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 40 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 243,326.4 мянган төгрөгийн 37 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх, үнэн зөв батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 27,626.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10 Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Балансын дараах үйл явдалд анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Тайлант онд цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан биет тест хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар үндсэн хөрөнгө, бараа материалыг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг 2,989.6 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, худалдан авалт бодитоор хийгдэхгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт /и баримт/-ыг авч, борлуулагч байгууллагад цахим баримтын системд баримтыг оруулах шаардлага тавьж хэвших;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

И баримтын бүртгэлийн хувьд аж ахуйн нэгж байгууллагууд төсвийн байгууллага НӨАТ төлөгч биш тул эцсийн хэрэглэгчээр шивэх асуудал их гардагтай холбоотой энэ зөрчил үүссэн. Цаашид хамтран ажилладаг ААН, байгууллагуудад хэлж, анхааруулан, тогтмол цаг хугацаанд И-баримтад бүртгүүлж, дээрх алдааг давтан гаргахгүй, хяналт тавьж ажиллана.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материал дансанд 5,426.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн ба хөрөнгийн ангилал буруу хөтөлсөн зөрчил нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.16-т "Бараа материал болон үндсэн хөрөнгийг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, бодитой оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн заавар журам хэрэгжихгүй, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл бодитой илэрхийлэгдэхгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материал, үндсэн хөрөнгийг бүртгэхдээ холбогдох нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу зөв ангилж бүртгэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Бараа материалын дансанд бүртгэгдсэн дээрх хөрөнгө нь амархан элэгдэж, эвдрэх хөрөнгө байсан тул уг дансанд бүртгэсэн. Цаашид өмч хамгаалахын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, ерөнхий захирлын тушаал гаргуулан, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх болно.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Хангамжийн материал дансанд 231.8 мянган төгрөгийн хүнсний материал бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.16 “Бараа материал болон үндсэн хөрөнгийг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө” гэсэн заалтыг санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн заавар журам хэрэгжихгүй, бараа материалын үлдэгдэл бодитой илэрхийлэгдэхгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг бүртгэхдээ холбогдох нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу зөв ангилж бүртгэх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2020 оны 11 дүгээр сард тус төвийг төгсөн гарч амьдралд хөл тавьсан хүүхдүүдээ хүлээн авч “Эргэн дурсахуй” гэр бүлийн уулзалтыг зохион байгуулсан. Уг үйл ажиллагааны зардалд НГБХЗГ-аас үзүүлсэн дэмжлэгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч хүнсний материал авсан бөгөөд төвийн хүүхдийн хүнснээс ялгах зорилгоор хангамжийн дансанд бүртгэсэн болно. Цаашид орлого авахдаа дансаа хянаж байна.

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Бараа материал дансанд 15,949.1 мянган төгрөгийн шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4. үнэн зөв байх; 5.1.5. хэмжигдэхүйц байх”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 2.1.4-т “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх” гэсэн заалтуудтай нийцээгүй, үнэн зөв байдал, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн заавар журам хэрэгжихгүй, бараа материалын үлдэгдэл бодитой илэрхийлэгдэхгүй байх.

4.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг бүртгэхдээ холбогдох нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу нэр төрөл, тоо хэмжээгээр нь орлого, зарлагаар бүртгэх.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Шатахууныг шаардах хуудас болон олгосон талоноор бүртгэсэн бөгөөд нэр төрөл, тоо хэмжээгээр бүртгээгүй нь мөнгөний зөрүү гаргах байсан тул талон, шаардахаар бүртгэсэн болно. Цаашид шатахууныг бүртгэлд авахдаа нэр төрөл, тоо хэмжээгээр дотоод гүйлгээгээр давхар бүртгэх болно.

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Цалин хөлсийг бодохдоо 3,029.1 мянган төгрөгийн цалинг цагийн бүртгэлээс дутуу бодсон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйл 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцээгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:

Багш ажилчдын цалин хөлс бодитоор олгогдохгүй, санхүүгийн үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

5.3. Өгсөн зөвлөмж:

Цалин хөлсийг бодохдоо батлагдсан ажилчдын цагийн бүртгэлийг үндэслэн тооцож байх.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цагийн бүртгэлийг үндэслээгүй шалтгаан нь зарим албан хаагчдын илүү цагийг тал хувийг цалин хөлсөөр, зарим цагийг биеэр эдлүүлдэг.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Өнөр бүл хүүхдийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/156/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Өнөр бүл хүүхдийн төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл Нэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууны зардлыг автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормоос илүү зарцуулсан ба жолоочийн замын хуудас маш их засвартай, шатахууны анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.	2,888.1	Төлбөрийн акт тогтоох	Захирал Ахлах нягтлан бодогч	М.Өлзийчимэг Б.Долзодмаа
2	Оны эцэст шатахуун авч нөөцөлсөн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг зөрчсөн.	16,212.5	Албан шаардлага өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	М.Өлзийчимэг Б.Долзодмаа
3	Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 37 гүйлгээг мэдээлээгүй, 40 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчил нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 заалтыг зөрчсөн байна.	243,326.4	Албан шаардлага өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	М.Өлзийчимэг Б.Долзодмаа
4	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг дутуу бүрдүүлсэн зөрчил нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.	2,989.6	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	М.Өлзийчимэг Б.Долзодмаа
5	Бараа материал дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн ба хөрөнгийн ангилал буруу хөтөлсөн зөрчил нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.	5,426.9	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	М.Өлзийчимэг Б.Долзодмаа
6	Хангамжийн материал дансанд хүнсний материал бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, бодитой оршин байх гэсэн	231.8	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	М.Өлзийчимэг Б.Долзодмаа

	батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.				
7	Бараа материал дансанд шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгосон талоноор зардалд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.	15,949.1	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	М.Өлзийчимэг Б.Долзодмаа
8	Цалин хөлсийг бодохдоо цагийн бүртгэлээс дутуу бодсон зөрчил нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй.	3,029.1	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	М.Өлзийчимэг Б.Долзодмаа
ДҮН		290,053.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 28/АД160060

Улаанбаатар хот

САГ-2021/156/СТД-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өнөр бүл хүүхдийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууны зардлыг автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормоос 2,888,100 төгрөгөөр илүү зарцуулсан ба жолоочийн замын хуудас засвартай, шатахууны анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 3 бүлэг "Зардлыг хүлээн зөвшөөрөх ба үнэлэх" хэсгийн 3.2 дахь заалт "... гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өнөр бүл хүүхдийн төвийн шатахууны нормативт зардлаас илүү зарцуулсан 2,888,100 /хоёр сая найман зуун наян найман мянга нэг зуу/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Өнөр бүл хүүхдийн төв"-ийн дарга М.Өлзийчимэг, ерөнхий нягтлан бодогч Б.Долзодмаа нарт хариуцуулав.

АКТЫГ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
"ИХ НАЯД АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЦЭРЭНДОРЖ
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264330

9008109
901012

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Akt\2021\0225auditin 2-R Газар32.Docx

001090481



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 99/А0160060

Улаанбаатар хот

САГ-2021/156/СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өнөр бүл хүүхдийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өнөр бүл хүүхдийн төв нь оны эцэст 16,212.5 мянган төгрөгийн шатахуун авч нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн, зарцуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Өнөр бүл хүүхдийн төв"-ийн дарга М.Өлзийчимэг, ерөнхий нягтлан бодогч Б.Долзодмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

"ИХ НАЯД АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЦЭРЭНДОРЖ

Х.АРИУНЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 100/А0160060

Улаанбаатар хот

САГ- 2021/156/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өнөр бүл хүүхдийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд нийт 476 мэдээлэл байршуулахаас 40 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 243,326.4 мянган төгрөгийн 37 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-д тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Өнөр бүл хүүхдийн төв"-ийн дарга М.Өлзийчимэг, ерөнхий нягтлан бодогч Б.Долзодмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР 
"ИХ НАЯД АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЦЭРЭНДОРЖ
Х.АРИУНЗУЛ